



Олон Улсын Хөдөлмөрийн
Байгууллага



Хүчирхийллийн Эсрэг
Үндэсний Төв

БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ, МӨЛЖЛӨГИЙН ХОХИРОГЧ ХҮҮХДИЙН ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ НЬ

ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ 2010 он

“БЭЛГИЙН МӨЛЖЛӨГ, ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДИЙН
ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ НЬ”

Энэхүү тайланг Америкийн Нэгдсэн Улсын Хөдөлмөрийн Департаментын
санхүүгийн дэмжлэгтэйгээр хэвлүүлэв.

Аналитик тайланг боловсруулсан:

Г.Оюунболд

Хянан тохиолдуулсан:

Б.Арвинариа, Н.Монголмаа

Хэвлэлд бэлтгэсэн:

С.Байгалмаа

“БЭЛГИЙН МӨЛЖЛӨГ, ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДИЙН
ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ НЬ”

АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт	4
Өмнөх үг	5
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УДИРТГАЛ	6
1.1. Зорилго	6
1.2. Бэлгийн мөлжлөгийн тодорхойлолт, ойлголт	6
Олон Улсын эрх зүйн хэм хэмжээ	6
1.3. Монгол Улсын хэмжээнд хүүхдийг бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгт ашиглах гэмт хэрэг үйлдэгдэж байгаа нөхцөл байдал	8
ХОЁРДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ	10
2.1. Монгол Улсын эрх зүйн хэм хэмжээ	10
2.2. Хуулийн давхардал	12
ГУРАВДУГААР БҮЛЭГ. ХҮҮХДИЙН БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ, МӨЛЖЛӨГТЭЙ ХОЛБОГДОХ ГЭМТ ХЭРГИЙГ ШИЙДВЭРЛЭХ ЯВЦАД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ	14
3.1. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шат	14
3.2. Шүүхийн шат	16
3.3. Хохирогч хүүхдийг хамгаалах асуудлаар практикт тулгарч буй бэрхшээл	16
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ДҮГНЭЛТ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ	18
4.1. Үйл ажиллагааны хүрээнд өгөх дүгнэлт	18
4.2. Эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох санал	19
4.3. Хуулийн байгууллагын үйл ажиллагаанд өгөх зөвлөмж	20
4.4. Хохиргчийг нөхөн сэргээх, нийгмийн ажил, үйлчилгээг сайжруулах талаарх зөвлөмж	20
ТАВДУГААР БҮЛЭГ. БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ, МӨЛЖЛӨГТ ӨРТСӨН ХҮҮХДИЙН ЗӨРЧИГДСӨН ЭРХИЙГ СЭРГЭЭХ ТАЛААР ӨМГӨӨЛӨГЧ, МӨРДӨН БАЙЦААГЧИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ	21
5.1. Өмгөөлөгчдөд зориулсан зөвлөмж	21
5.2. Мөрдөн байцаагчдад зориулсан практик зөвлөмжүүд	23
ХАВСРАЛТ	27
Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэргийн хохирогч хүүхдийг нөхөн сэргээх үйлчилгээний эрх зүйн боломж	27

Товчилсон үгийн жагсаалт

ГБХТТХ	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
МУ	Монгол Улс
МДШТ	Мэдээлэл, дүн шинжилгээний төв
НҮБ	Нэгдсэн Үндэстний байгууллага
ОУХБ	Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага
ӨҮХТ	Өсвөр үеийнхний хөгжлийн төв
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ТББ	Төрийн бус байгууллага
УДШ	Улсын Дээд шүүх
ЦЕГ	Цагдаагийн Ерөнхий газар
ХЭҮТ	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв
ХХГХ	Хүн худалдаалах гэмт хэрэг
ХЭХТХ	Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль
ХТЭТ	Хүйсийн тэгш эрхийн төв
ЭБШХ	Эрүүгийн байцаан шийтгэх хууль
ЭБША	Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа
ЭХ	Эрүүгийн хууль
ЭЭЗКС	Эрүүгийн эрх зүйн криминологийн сектор

Өмнөх үг

Монгол улсад бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртөж буй хүүхдийн тоо нэмэгдэж байгаа гэдгийг олон байгууллагууд хүлээн зөвшөөрч байна¹. Монгол улс нь НҮБ-ын Хүүхдийн эрхийн Конвенцид 1999 онд, Хүүхдийг бэлгийн мөлжлөгөөс хамгаалах протоколд 2002 онд, ОУХБ-ын Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай 182 дугаар Конвенцид 2002 онд, Хүн худалдаалах, ялангуяа хүүхэд эмэгтэйчүүдийг худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох Палермогийн протоколд 2008 онд тус тус нэгдэн орсон.

Эдгээр олон улсын баримт бичгүүд нь улс орнуудыг хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд болон хүүхдийн бэлгийн мөлжлөгийг таслан зогсоох, хохирогч хүүхдийг нөхөн сэргээх арга хэмжээг хойшиулшгүй авахыг шаарддаг. Гэвч эдгээр Конвенцийн хэрэгжилт сул байсаар байна. Энэ нь бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгөөс хүүхдийг хамгаалах, гэмт хэрэгтнийг шийтгэх эрх зүйн орчин сул, бэлгийн мөлжлөг, хүчирхийллийн хохирогч хүүхдүүдийг хамгаалах, дэмжлэг үзүүлэх, нөхөн сэргээх үйлчилгээ дутагдалтай байгаатай холбоотой юм.

Хохирогч хүүхдэд ээлтэй хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэхэд нөлөөлөх зорилгоор “Бэлгийн хүчирхийлэл мөлжлөгийн хохирогч хүүхдийг хамгаалах эрх зүйн орчныг сайжруулах” төслийг Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Хүүхдийн хөдөлмөрийг устгах олон улсын хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр Хүчирхийллийн Эсрэг Үндэсний төв, Өсвөр үеийнхний хөгжлийн төв, Хүүхэд, залуучуудын хөгжил, хамгаалал төв, “Хүүхдийн эрхийн үндэсний төв” төрийн бус байгууллагууд хамтран хэрэгжүүллээ.

Уг төслийн үр дүнд Монгол Улс дахь хүүхдийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийг бүрэн хориглох, хохирогч хүүхдийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ, үйлчилгээний эрх зүйн орчныг боловсронгуй болгох, тэдгээрийн бодит хэрэгжилтийг сайжруулахад хувь нэмэр оруулах зорилгоор энэхүү тайланг бэлтгэлээ.

Дүн шинжилгээний тайланг боловсруулахад хуулийн зөвлөхөөр ажилласан Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрүүгийн эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан Г.Оюунболд, хууль зүйн үүднээс хянан шүүсэн Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн “Эрх зүйн шинэчлэл” хөтөлбөрийн зохицуулагч, хуульч Б.Арвинтариа болон тайланг хэлэлцүүлэхэд үнэтэй санал, зөвлөмж өгсөн бүх хүмүүст талархал илэрхийлье.

¹ Монгол улсын Засгийн газар, 2004 он.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УДИРТГАЛ

1.1. Зорилго

Монгол Улс дахь хүүхдийг бэлгийн мөлжлөгт ашиглах, бусад байдлаар хүчирхийлэх гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг тодорхойлж, энэ гэмт хэрэгт өртсөн хохирогч хүүхдийн эрх ашгийг хамгаалах арга замыг боловсронгуй болгох зорилготой ажиллав.

Төслийн хүрээнд дараах стратегийг хэрэгжүүллээ:

- Хүүхдийн бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн 20 хэргийг шийдвэрлүүлэх явцад дүн шинжилгээ хийх замаар эрх зүйн орчны дутуу, давхардсан болон давуу талыг тодорхойлох, хуулийн байгууллагын практик үйл ажиллагаанд гарч буй нийтлэг доголдолтой асуудлыг тодорхойлох, энэ талаар санал зөвлөмж боловсруулах;
- Бэлгийн мөлжлөгт өртсөн, хохирогч хүүхдийг хамгаалах талаар хуулиар хориглоогүй бусад боломжийг тодорхойлох;
- Бэлгийн мөлжлөгийн хохирогч хүүхдүүдэд үйлчилгээ үзүүлэх хуулийн болон нийгмийн халамж, үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагааг хэрхэн сайжруулах дүгнэлт, санал боловсруулах;
- Дүгнэлт, санал, зөвлөмжийг хууль тогтоогч, бодлого боловсруулагчдад танилцуулах, хууль эрх зүйн орчин, хуульчдын практик арга ажиллагаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, сайжруулахад нөлөөлөх.

Тайланг бичихдээ дараах судалгааны аргыг ашиглав. Үүнд:

- Баримт бичгийн судалгааны арга: Шүүхийн шийтгэх тогтоол, тоо мэдээ, статистик үзүүлэлтүүдийг судлах;
- Кейс судалгааны арга: Сонгон авсан кейсүүдийг шийдвэрлүүлэх явцад гарч байсан бэрхшээл, ололт амжилт, асуудлуудыг тодорхойлох;
- Ярилцлагын арга: Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн байгууллагын ажилтнууд болон нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нартай ярилцлага хийх, тэдний үзэл бодлыг сонсох;
- Дүн шинжилгээний арга: Цугларсан мэдээ сэлт, кейс, баримт, фактад бодитой дүгнэлт өгөх замаар дүн шинжилгээ хийж, мөн чанарыг нээн илрүүлэх, ерөнхийгөөс тусгай руу чиглүүлэх анализ судалгаа.

1.2. Бэлгийн мөлжлөгийн тодорхойлолт, ойлголт

Олон Улсын эрх зүйн хэм хэмжээ

НҮБ-ын Хүүхдийн эрхийн Конвенц. Хүүхэд эдийн засгийн мөлжлөгөөс хамгаалуулах, боловсрол эзэмшихэд нь саад болох буюу эсвэл түүний эрүүл мэнд, бие бялдар, сэтгэц, оюун санаа, ёс суртахууны болон нийгмийн хөгжилд нь хор уршиг учруулж болзошгүй аливаа ажлаас хамгаалуулах эрхийг хүлээн зөвшөөрөх, мөн хүүхдийг бэлэгсийн хууль

“БЭЛГИЙН МӨЛЖЛӨГ, ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДИЙН ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ НЬ”

бус аливаа ажиллагаанд татан оролцуулах, хүүхдийг биеэ худалдах, садар самууны зүйл, садар самуун явдлыг дүрсэлсэн материал болон бэлэгсийн хууль бусад хэрэгт ашиглахаас урьчилан сэргийлэхэд чиглэсэн үндэсний, хоёр талын, олон талын бүхий л тохирох арга хэмжээг авахыг энэ Конвенц шаарддаг.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн Конвенцийн Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуундашиглахын эсрэг Нэмэлт Протокол. Энэхүү Протокол нь оролцогч улсуудыг арилжааны бэлгийн мөлжлөгт өртөх эрсдэлтэй хүүхдийг хамгаалахад онцгой анхаарал хандуулж, хохирогч хүүхдэд шаардлагатай бүх тусlamж, үүний дотор тэднийг нийгмийн ердийн амьдралд эргүүлэн оруулах, бие маходийн хийгээд сэтгэл зүйн хувьд бүрэн нөхөн сэргээх арга хэмжээ авахыг шаарддаг.

ОУХБ-ын Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай конвенци¹ нь түүнийг соёрхон баталж буй гишүүн орнуудаас хүүхдийг биеэ үнэлэх үйлажиллагаа, садар самууны сурталчилгаа болон садар самууны үзүүлбэрт ашиглах, элсүүлэн авах эсвэл үүнийг санал болгохыг (Заалт 3 (б)) хориглох болон арилгах үр дүнтэй арга хэмжээнүүдийг нэн даруй авч хэрэгжүүлэхийг шаардజээ.

Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын Конвенцийн “Хүнийг, ялангуяа эмэгтэйчүүд болон хүүхэд худалдаалахаас урьчилан сэргийлэх, таслан зогсоох ба ял шийтгэх тухай” Протокол. Уг Протоколд **хүн худалдаалах гэж “ашиг олох зорилгоор бусдыг хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, эсхүл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эмзэг байдлыг нь далимдуулах, эсхүл өөр этгээдийг хяналтандaa байлгаж байгаа этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр хийх, хахуульдаа замаар хүнийг элсүүлэх, зөөх, тээвэрлэх, дамжуулах, нуух буюу хүлээн авах”**-ыг ойлгоно гэжээ. Түүнчлэн Протоколд дараахь асуудлыг тодорхойлсон:

- “ашиг олох” гэдэгт бусдын биеийг үнэлүүлэх болон бэлгийн харилцааны бусад хэлбэрээр мөлжих, албадан хөдөлмөр, үйлчилгээ хийлгүүлэх, боолчлолын нөхцөлд байлгах, бие эрхтнийг нь авах зэргийг хэлнэ гэжээ. Энэ тодорхойлолтод ашиг олох, мөлжих нь хүчирхийллийн шинжтэй аливаа үйлдлийг заавал агуулсан байх тухай утгыг ер хамааруулахгүй байна.
- Хүн худалдаалах гэдэгт хамаарах арга замыг хэрэглэсэн л бол хохирогч зөвшөөрсөн эсэхийг үл харгалзана.
- Хэдийгээр дээр дурдсан арга замын алиныг нь ч хэрэглээгүй байлаа гэсэн ашиг олох зорилгоор хүүхдийг элсүүлсэн, зөөсөн, тээвэрлэсэн, дамжуулсан, нуусан, хүлээн авсан бол “хүн худалдаалах” гэмт хэрэгт тооцно гэж заажээ.

ОУХБ-ын Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай 182 дугаар Конвенц² Хүүхдийг биеэ үнэлэх үйл ажиллагаа, садар самууны сурталчилгаа болон садар самууны үзүүлбэрт ашиглах, элсүүлэн авах эсвэл үүнийг санал болгохыг (Заалт 3 (б)) хориглох, устгах үр дүнтэй арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэхийг түүнийг соёрхон баталж буй гишүүн орнуудаас шаардсан.

¹ ОУХБ-ын Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай конвенц, 1999 он (№182)

² ОУХБ-ын Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай конвенц, 1999 он (№182)

“БЭЛГИЙН МӨЛЖЛӨГ, ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДИЙН ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ НЬ”

1.3 Монгол улсын хэмжээнд хүүхдийг бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгт ашиглах гэмт хэрэг үйлдэгдэж байгаа нөхцөл байдал

Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийг хамгаалах хууль, эрх зүйн орчинд зарим дэвшил гарсан боловч энэ төрлийн гэмт хэрэг нуугдмал байдгаас шалтгаалж хуулийн байгууллагуудаар шийдвэрлэгдсэн хэргүүд тун цөөн байна. Судалгааны дүнгээс үзэхэд Улаанбаатар хот болон хилийн боомтын хот, суурингуудад хүүхдийн бэлгийн мөлжлөг нэмэгдэж, орон нутагт үйлдэгдэж байгаа гэмт хэрэг илрэхгүй байна.

Бэлгийн мөлжлөгт өртсөн охидын нэлээд нь гэр бүл дэх хүчирхийлэл, зөрчилдөөний улмаас орон гэрээсээ дайжсан хүүхдүүд байдаг. 2008 оны ХҮЭК-ийн тайлангаас үзэхэд олон жил тэнэмэл амьдралаар айл, халамжийн төв дамжин амьдардаг, хөдөө орон нутгаас нийслэлд нүүж суурьшсан, ядуу өрхийн сургууль завсардсан, гэр бүлийн хүчирхийлэлд өртдөг, зах дээр хөдөлмөр эрхэлдэг, эцэг эх нь салсан, хойд эцэгтэй гэр бүлийн охид бэлгийн мөлжлөгт илүү ихээр өртөж байна.³

Хүүхдийн бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгийн гэмт хэргүүд дараах хэлбэртэй байна:

- Биеийг нь үнэлүүлэх;
- Хүчиндэх;
- Садар самуунд уруу татах;
- Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах;
- 16 насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдэх;
- Хүн худалдаалах.

Гэмт хэрэг бүртгэгдсэн байдал. ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээний төвөөс гаргасан хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг хэргийн сүүлийн 4 жилийн статистик үзүүлэлт⁴:

- 2006 онд энэ төрлийн гэмт хэрэг 2005 оныхоос 10 хувиар буурсан байна.
- 2007 онд мөн өмнөх оныхоос 12.0 хувиар буурсан байна. Гэмт хэргийн улмаас 19931 иргэн хохирсны 5.8 хувь нь насанд хүрээгүй хүүхэд байжээ.
- 2008 онд энэ гэмт хэрэг бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 2.1 хувийг эзэлж, өмнөх оныхоос 10.9 хувиар өсчээ.
- 2009 онд нийт 375 гэмт хэрэг бүртгэгдэн, урд оныхоос 12 хувиар буурсан байна. Гэмт хэргийн улмаас 19545 хүн хохирсны 5.3 хувь нь хүүхэд байна.

Үүнээс үзэхэд хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг тогтвортой буурахгүй байгаа нь харагдаж байна. Бүртгэгдсэн хэргийн тоо нэг онд өсч, нөгөө онд нилээд буурсан хандлагатай байгаа нь гэмт хэргийн илрүүлэлттэй холбоотой гэж үзэж байна. Мөрдөн байцаагч нартай хийсэн бүлгийн ярилцлагын судалгаанаас үзэхэд энэ төрлийн гэмт хэрэг цөөн тоотой гарч бүртгэгддэг, ихэвчлэн нууц далд байдалд байдалг

3 ХЭҮК-ийн тайлан, 2008 он, 46-р тал

4 ЦЕГ-ас жил бүр гаргадаг гэмт хэргийн мэдээнээс

“БЭЛГИЙН МӨЛЖЛӨГ, ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДИЙН ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ НЬ”

байна.⁵ Ийнхүү насанд хүрээгүй хүмүүсийн эсрэг үйлдсэн гэмт хэргийн илрүүлэлт бага байгаа нь энэ төрлийн гэмт хэрэг улам нэмэгдэж, даамжирахад нөлөөлж байна.

Хуулийн хэрэгжилт сүл байгаа шалтгааныг судлан үзэхэд хуулийн байгууллагад энэ төрлийн гэмт хэргийн мэдээлэл ирдэггүй, бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэг ихэвчлэн гэр бүлийн хүрээнд үйлдэгддэг, гэмт хэргийн хохирогч хүүхдийн өмнөөс нэхэмжлэл гаргах субъект байхгүй байгаатай холбоотой байна⁶.

Нийслэлийн цагдаагийн газрын олон нийттэй харилцах хэлтсийн мэдээнээс үзвэл биеэ үнэлдэг нь тогтоогдсон, хүүхдийн байцаагчийн хяналтанд байдаг насанд хүрээгүй охидын тоо 2005 онд 93, 2006 онд 156, 2007 оны эхний 9 сарын байдаар 127 байна.

Шүүхээр шийдвэрлэгдсэн байдал: Хүн худалдаалах гэмт хэрэг болон биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхэд зохион байгуулах гэмт хэрэгт 2002-2008 онд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 113 дугаар зүйлээр 4 хэрэгт 4 хүн, 124 дүгээр зүйлээр 32 хэрэгт 53 хүн ял шийтгүүлсэн байна.

124 дүгээр зүйлд заасан гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн 65 хувь нь эмэгтэйчүүд, 73 хувь нь 19-35 насны хүмүүс байна.

2009 онд Улсын Дээд Шүүхээс Хүн худалдаалах гэмт хэргийн талаар тайлбар гарч, төрийн болон төрийн бус байгууллагуудаас тодорхой давтамжтай сургалт, сурталчилгаа явуулснаар дээрх гэмт хэргийн шийдвэрлэлт харьцангуй сайжирчээ. Хэдий тийм ч зарим гэмт этгээдүүдэд захиргааны арга хэмжээ авах, тортог төдийгөөр ял завшуулж, өөгшүүлж байгаа нь хууль тогтоомжийн давхардалтай холбоотойгоос гадна хуулийн байгууллагын санаачлага бүхий үйл ажиллагаа дутсантай холбоотой байна.

5 “Эрүүгийн хуулийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгааны тайлангаас, ХЗҮХ, ЭЭЗКС, 2009 он

6 Төслийн хүрээнд УМБГ-тай хамтран зохион байгуулсан 15 мөрдөн байцаагчтай хийсэн ярилицлагын судалгаанаас, ХЗҮХ, 2009 оны 11 сарын 12

ХОЁРДУГААР БҮЛЭГ

МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

2.1 Монгол Улсын эрх зүйн хэм хэмжээ

Монгол Улсын хууль, тогтоомжийн хүрээнд хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй арилжааны шинжтэй бэлгийн мөлжлөгийг Эрүүгийн хуулийн 115 дугаар зүйлийн 115.1. “Насанд хүрээгүй хүнийг биеэ үнэлэхэд татан оролцуулах” гэсэн зүйлээр зохицуулж байна.

<p>115 дугаар зүйл. Насанд хүрээгүй хүнийг согтуурал, мансуурал, биеэ үнэлэх, тэнүүчлэл, гуylanчлалд татан оруулах</p> <p>115.1. Насанд хүрээгүй хүнийг согтуурал, мансуурал, тэнүүчлэл, гуylanчлал болон биеэ үнэлэхэд татан оруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.</p> <p>115.3. Энэ хэргийг давтан, эсхүл хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>	<p>124 дүгээр зүйл. Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах</p> <p>124.1. Хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, хуурч мэхлэх замаар биеэ үнэлэхэд татан оролцуулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас хоёр зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.</p> <p>124.3. Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>
--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Хүүхдийн биеийг үнэлүүлсэн этгээд насанд хүрсэн хүний биеийг үнэлүүлснээс хөнгөн ял шийтгэгдэхээр хуульчилсан ба хүүхдийн биеийг бусдад төлбөртэй үнэлүүлж мөлжих нь “хөнгөн” гэмт хэрэгт тооцогдож байна. Энд хүүхдийн эрхийг хэт дорд үзсэнээс гадна Эрүүгийн хуулийн “гэм буруутай этгээдэд үйлдсэн гэмт хэрэгт нь тохирсон хариуцлага хүлээлгэх” зарчимтай нийцэхгүй байна.

“Насанд хүрээгүй биеэ үнэлэгч” гэсэн ойлголт байхгүй бөгөөд насанд хүрээгүй хүнийг бэлгийн харьцаанд төлбөртэй оруулсан тохиолдол бүрийн цаана хүүхэд хэн нэгэн этгээдийн эрхшээлд байдаг шинжийг хууль тогтоогч орхигдуулснаас гэмт этгээдүүдэд ял завших, энэ төрлийн гэмт хэргийг өөгшүүлэх боломжийг бүрдүүлжээ.

Монгол Улсын Дээд шүүхээс: “124 дүгээр зүйлийн 124.1-д заасан “биеэ үнэлэхэд татан оролцуулсан” гэж шунахай болон хувийн бусад сэдэлтээр,... хохирогчийг бусадтай

“БЭЛГИЙН МӨЛЖЛӨГ, ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДИЙН ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ НЬ”

бэлгийн харьцаанд төлбөртэй оруулахыг хэлнэ” гээд Эрүүгийн хуулийн 115 дугаар зүйлийн 115.1-д заасан “биээ үнэлэхэд татан оруулсан” гэдгийг дээрхтэй нэгэн адилаар ойлгож, хэрэглэнэ” гэж тайлбарлажээ.

Хууль тогтоогч ямар шаардлагын улмаас насанд хүрээгүй хүнийг бэлгийн харьцаанд төлбөртэй оруулж мөлжих үйлдлийг “биээ үнэлэхэд татан оролцуулах” гэж үзэх болсон, яагаад хөнгөн гэмт хэрэгт тооцсон, ямар шалтгааны улмаас Эрүүгийн хуулийн 115 дугаар зүйлд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж болгон авч үзсэн нь тодорхойгүй байна. Энэ нь Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйл буюу “Хүн худалдаалах” гэмт хэргийн бүрэлдэхүүний хүндрүүлэх бүрэлдэхүүнд шууд хамаарч байна.

Иймд Эрүүгийн хуулийн 115 дугаар зүйлээс “биээ үнэлэхэд татан оруулах” гэснийг хасч, Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйл, 124 дүгээр зүйлийн хүндрүүлэх бүрэлдэхүүн болгон зүйлчлэх нь зохимжтой гэж үзлээ.

Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “....Хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, хуурч мэхлэх замаар биээ үнэлэхэд татан оролцуулсан...” гэж тодорхойлсон нь томъёоллын хувьд эргэлзээ, маргаан үүсгэх нэг хүчин зүйл болж байна.⁷ Монгол Улсын нэгдэн орсон олон улсын эрх зүйн хэм хэмжээ болон Монгол Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд 18 насанд хүрээгүй хүнийг “хүүхэд” гэж үздэг⁸. Насанд хүрсэн хүн хүүхэдтэй бэлгийн харьцаанд орох нь хүч хэрэглэсэн, хэрэглээгүй, хүүхэд зөвшөөрсөн эсэхээс үл хамааран гэмт хэрэг гэж үзэх ёстой. Гэтэл манай Эрүүгийн хуулиар 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орсон тохиолдолд л эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нь⁹ 16-17 насны хүнтэй хүч хэрэглээгүй бол бэлгийн харьцаанд орж болохыг зөвшөөрсөн зохицуулалт болжээ.

Эрүүгийн хуулийн 122 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг “Насанд хүрсэн этгээд хохирогчийг насанд хүрээгүй гэдгийг мэдсээр байж хурьцал үйлдсэн бол...” гэж өөрчлөх шаардлагатай байна.

“Садар самуун явдалтай тэмцэх тухай” хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т “садар самуун явдал” гэж биээ үнэлж явалдах, түүнд бусдыг уруу татах, биээ үнэлэхийг зохион байгуулах, зуучлах, түүнчлэн садар самууныг сурталчлахыг” гэж тодорхойлсон нь Эрүүгийн хуулийн 123 дугаар зүйл дэх Садар самууныг сурталчлах, 124 дүгээр зүйл дэх “Биээ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биээ үнэлэхийг зохион байгуулах” гэмт хэргийн шинжийг агуулсан боловч эрүүгийн бус захиргааны хариуцлага ногдуулж болохоор байна. Тухайлбал: Насанд хүрээгүй хүний биеийг хүчээр үнэлүүлж, бэлгийн мөлжлөгт өртүүлсэн үйлдлүүд нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй”, гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй, нийгэмд аюулгүй үйлдэл¹⁰ биш.

Гэтэл цагдаагийн ажилтнууд Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хуулийн дээрх давхардлыг ашиглан “Садар самуунд уруу татах”, “Садар самууныг сурталчлах” гэсэн зүйлээр гэмт этгээдүүдэд захиргааны шийтгэл хүлээлгэн ял завшуулж байна.

7 “Хүн худалдах гэмт хэргийн шийдвэрлэлт” судалгааны тайлангаас, ХТЭТ, 2009 он

8 Монгол Улсын нэгдэн орсон НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенц, ОУХБ-ын 182 дугаар Конвенц, Палермогийн Протокол

9 Монгол Улсын Эрүүгийн хуулийн 122 дугаар зүйл

10 Монгол Улсын Дээд шүүхийн 2007 оны 45-р тогтоогоос

“БЭЛГИЙН МӨЛЖЛӨГ, ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДИЙН ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ НЬ”

Кейс 1. ...Намайг Б, Г хоёр айлгаж сүрдүүлээд авч явсан. Манай тэр хавийн охид тэднээс маш их айдаг. Тэднийг “Охин зардаг” гэж ярьдаг юм. Тэр 2 зочид буудалд нэг ахтай уулзаж, тэрнээс 15.000 төгрөг аваад тэр хүнтэй унт гээд нэг өрөөнд оруулсан. Би тэр ахад “Ахаа, би бие үнэлэгч бишээ, хүмүүс намайг хүчээр авчирсан юм...” гэж гуйхад тэр ах орхиод гарсан. Манай найзууд цагдаа дуудсан чинь Баянзүрх дүүргийн Цагдаагийн хэлтэс дээр намайг худалдсан 2 эмэгтэйг надтай хамт аваачаад тэр 2-ыг “нөгөө л ажлаа хийж явна уу?” гээд 15.000 төгрөгөөр торгоод явуулчихсан. Би тэднээс маш их аиж байна.

ХЭҮТ-ийн хамгаалах байранд байрлаж байсан насанд хүрээгүй хохирогч У-гийн гомдоос

Баримт: Эрүүгийн цагдаагийн газраас гаргасан мэдээгээр улсын хэмжээнд биеэ үнэлсэн гэсэн үндэслэлээр захиргааны арга хэмжээ авагдсан насанд хүрээгүй хүүхдүүд 2005 онд 380, 2006 онд 412, 2007 онд 426 /давхардсан тоогоор/ болж өссөн байна.

2.2. Хуулийн давхардал

Хүүхдийг бэлгийн мөлжлөгт ашигласан үйлдэлд хариуцлага оногдуулах зарим хэм хэмжээ Эрүүгийн хууль, бусад хуульд давхардан зохицуулагдсан нь гэмт этгээдэд ял завших, гэмт үйлдлээ дахин давтах боломжийг олгож байна. Үүнд:

- Эрүүгийн хуулийн 115; 124 дүгээр зүйлийн “бие үнэлэхэд татан оролцуулах” нь хоорондоо; эдгээр зүйлүүдийн зарим шинж нь 113 дугаар зүйлийн шинжүүдтэй;
- Эрүүгийн хуулийн 115; 124 дүгээр зүйлүүдийн “бие үнэлэх татан оролцуулах” нь Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн “бие үнэлж явалдахад уруу татах”-тай давхарджээ. Түүнчлэн,

• Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль:

Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдэд сум, дүүргийн Засаг даргын шийдвэрээр дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

1/ хүүхдийг сэтгэл санааны болон бие махбодийн дарамтад байлгасан, хавчин шахаж хүч хэрэглэсэн иргэн, албан тушаалтныг 40000-50000 төгрөгөөр торгох буюу 30 хүртэл хоногоор баривчлах;

5/ хүүхдээр гүйлгээнийг гүйлгасан иргэн, эрүүл мэндэд нь харшлах ажил хөдөлмөр хийлгэсэн албан тушаалтныг 10000-20000 төгрөгөөр торгох;

6/ өөрийнх нь болон эцэг, эх, асран хамгаалагч, харгалzan дэмжигчийн зөвшөөрөлгүйгээр хүүхдийг мэдээлэл, сурталчилгаанд ашигласан, бусад хэлбэрээр хууль бусаар нэрийг нь барьж, ашиг олох эрүүл мэнд, амь насанд нь аюул учруулах тоглоом, наадамд оролцуулах үйл ажиллагаа явуулсан иргэн, албан тушаалтны олсон ашиг, орлогыг хурааж, 30000-60000 төгрөгөөр торгох;

Монгол Улсын Эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцох үйлдэлд энэ хуулиар хариуцлага хүлээлгэх боломжтой байгаа нь хуулийн давхардал гэж үзэж болохоор байна.¹¹

¹¹ ХЭҮХ-ийн ЭЭЗКС-оос хийсэн “Эрүүгийн хуулийн хэрэгжилт” судалгааны тайлангаас

“БЭЛГИЙН МӨЛЖЛӨГ, ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДИЙН ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ НЬ”

• Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль

Уг хуулийн 6 дугаар зүйл заасан бэлгийн хүчирхийлэл нь энэ хуулиар бус тухайн үйлдлийнхээ обьектив шинжээс хамаарч Эрүүгийн хуулийн тусгай анgid заасан бие даасан гэмт хэрэг болно. Жишээ нь, Хүүхдийг бэлгийн мөлжлөгт оруулж түүнээс ашиг орлого олсон бол 113 дугаар зүйл буюу “Хүн худалдаалах” болон “Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдэх”, “Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах”, “Хүчиндэх” гэмт хэргүүдийн аль тохирох зүйл, хэсгээр хариуцлага хүлээлгэх үйлдэл юм.

Харин бэлгийн эрх чөлөөтэй нь холбоогүй боловч хүүхдийг ямар нэг байдлаар ашиг олох хэрэгсэл болгосон, хүнд нөхцөлд байлгасан, албадан хөдөлмөр эрхлүүлж ашиг олсон, давуу байдал бий болгосон, өр төлбөрт түр хугацаагаар шилжүүлсэн зэрэг үйлдэл хийсэн, түүний улмаас ямар нэг гэм хор учирсан бол мөн Эрүүгийн хуулийн “Асран хамгаалах үүргээ урвуулах”, “Хүүхдийг албадан болон хүчээр хөдөлмөрлүүлэх” гэмт хэргийн шинжийг агуулж байдаг.

Дээрх хэлбэрүүд нь гэмт хэргийн шинжийг шууд агуулж байдаг учир “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хуулиар бус Эрүүгийн хуулиар тайлбарлаж хариуцлага хүлээлгэдэг байх нь зохимжтой юм.

Эрх зүйн аливаа зөрчлийн хариуцлага туйлын тодорхой байх ёстой. Гэтэл уг хуулийн 19.1-т “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд түүний үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанар, зөрчлийн байдал, учруулсан хохирлын хэмжээг харгалзан хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ” гэсэн нь иш татсан, хариуцлага тооцсон, алгасуулан иш татсан хэм хэмжээний аль нь болох нь мэдэгдэхгүй хэт “бөөрөнхий” байгаа юм.

Эдгээр заалтууд хариуцлагын үр нөлөөг багасгах, эрүүгийн хариуцлагаас зайлсхийх боломжийг олгож байгаа юм. Нэгэнт Эрүүгийн хуулиар хүлээлгэх хариуцлагын талаар дурдаж байгаа учраас захиргааны хариуцлагатай давхардуулан авч үзэх нь илүүц юм.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ХҮҮХДИЙН БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ, МӨЛЖЛӨГТЭЙ ХОЛБОГДОХ ГЭМТ ХЭРГИЙГ ШИЙДВЭРЛЭХ ЯВЦАД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

3.1.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шат

Гэр бүлийн хүрээнд үйлдэгдсэн бэлгийн хүчирхийлийн гэмт хэрэг тэр бүр цаг тухайдаа мэдээлэгдэхгүй байна. Хүчингийн гэмт хэрэгт өртсөн насанд хүрээгүй хохирогч сэтгэл зүйн цочрол, айdas, стресст хүчтэй ордгоос болж хүчиндүүлснээ бусдаас нуусан нь хэргийг нотлоход хүндрэл, бэрхшээл учруулж байсан. Ураг төрлийн хүчингийн гэмт хэрэг хожуу илэрдэг учир хэргийг нотлоход мөрдөн байцаагчаас тодорхой ур чадвар шаарддаг. Түүнээс гадна зөвхөн мэдүүлгэн нотлох баримт буюу хохирогч, гэрчийн мэдүүлэгт тулгуурлан хэргийг шийдвэрлэдэгтэй холбоотойгоор хохирогчид хөндлөнгөөс нөлөөлөх оролдлого их гардаг, үүнээс шалтгаалж насанд хүрээгүй хохирогч айх, дарамтанд орох, залхах, улмаар мэдүүлгээсээ буцах, мөрдөн байцаалтын шатанд хэргийн шийдвэрлэлт удаашрах зэрэг бэрхшээлүүд гарч байлаа.

Иймд хохирогч хүүхдийг анх хүлээн авсан эмч, мэргэжлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийн дүгнэлтийг шинжээчийн дүгнэлт, нотлох баримтын түвшинд авч үзэх, дүгнэлт хийх мэргэжилтний үүрэг, хариуцлагыг тодорхойлсон эрх зүйн зохицуулалтыг бий болгох нь зүйтэй юм.

Тогтмол бэлгийн мөлжлөгт өртүүлсэн үйлдэл нь хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг агуулсан байсан ч хүчирхийлсэн этгээдийг Захиргааны хариуцлагын тухай хуулиар торгож байна. Сонгогдсон хэргүүдийн нэг нь тогтмол бэлгийн мөлжлөгт өртүүлсэн, хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг агуулсан байсан ч цагдаагийн ажилтан хохирогчийг худлаа ярьж байна хэмээн буруутган “биэ үнэлэгч”, “өөрөө буруутай” гэсэн нүдээр харж, хүчирхийлсэн этгээдийг торгоод өнгөрөөжээ.

Цагдаагийн байгууллагын анхан шатны нэгж, хороонд ажиллаж байгаа хэсгийн байцаагч нарт энэ төрлийн гэмт хэргийг шийдвэрлэх, шалгах эрмэлзэл бага, ур чадвар дутагдалтай учир шалгахаас зайлсхийж, ажлаа хялбарчлахын тулд Захиргааны хариуцлагын тухай хуулийг хэрэглэжээ.

Хүүхдийн бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэргийг хүүхдийн асуудлаар мэргэшсэн мөрдөн байцаагч шалгадаг зарчимд шилжвэл шийдвэрлэгдэх боломжтой юм.

Хохирогчийн ар гэрийнхэн сэжигтэн этгээдүүдийн нөлөөнд орж хувиараа тохиролцон, цагдаагийн байгууллагад шалгуулахгүй, “гомдолгүй” хэмээн хэрэг үүсгүүлэхгүй, хэргийг хаалгах явдал байсаар байна.

“БЭЛГИЙН МӨЛЖЛӨГ, ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДИЙН ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ НЬ”

Холбогдгчийн талын ах дүү нар нь хохирогчийг мэдүүлгээ өөрчлөхийг шаардах, шан харамж амлах, заналхийлэх, хуурч мэхлэх үйлдлийг байнга гаргаж байсан ноцтой баримтууд бидний ажилласан хэргүүд дээр илэрсэн. Үүний гол шалтгаан нь хүчирхийлэгч нь хохирогчтой ойрын хамаатан, садан төрөл, танил талын холбоотой, хохирогч ямар нэг байдлаар хүчирхийлэгчийн эрхшээлд байдгаас шууд шалтгаалж байна.

Кейс 2. Намайг хүчиндүүлээгүй, өөрөө порно кино үзэж байгаад зөвшөөрсөн гэж хэлбэл чиний нэр дээр хашааныхаа талыг байшинтайгаа шилжүүлнэ гээд манай ээжтэй гэрээ хийсэн. Бас намайг “чи насанд хүрээгүй юм чинь худлаа хэлсэн гэж хэрэгтэн болохгүй” гэж ятгасан. Би ээж, дүү нартайгаа хамт гудамжинд гарахаасаа айгаад, тэгээд ч ээжийн минь эгчийн нөхөр болохоор аргагүйн эрхэнд зөвшөөрч худлаа мэдүүлэг өгсөн юм.

.....тоот хавтас т хэрэгт хохирогч Б-ийн өгсөн мэдүүлгээс

Цагдаагийн байгууллага насанд хүрээгүй хүүхдийн бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгийн талаарх мэдээлэл бүрийг шалгах шаардлагатай байна. Хохирогчийн аав, ээж, ах дүү, хамаатан садных нь хүсэлтээр хаах хууль бус явдлыг таслан зогсоох нь чухал.

Зарим хохирогч нарын анхны мэдүүлэг, тайлбарт “гомдолтой, хохирол нэхэмжилнэ” гэсэн байдаг боловч яваандаа “хохиролгүй, нэхэмжлэх зүйлгүй, гомдолгүй, шүүх хуралд суухгүй” гэхчлэн өөрчлөгдсөн нь анхаарал татах байлаа. Энэ бүхний ард хохирогчид бодит аюул занал, далайлган сүрдүүлэг байх магадлал өндөр учир хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар нь насанд хүрээгүй хүмүүсийн эсрэг үйлдэгдэж байгаа бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл болон түүнтэй адил төстэй гэмт хэргийг шалган шийдвэрлэхдээ дээрх нөхцөл байдлуудыг анхаарч “хэвшмэл арга барил”-аас ангижирч, шинэ туршлагыг нэвтрүүлэх хэлбэрээр ажиллах шаардлагатай байна.

Хохирогчийн шүүх эмнэлгийн үзлэгийг төлбөртэй хийж байна. Шүүх эмнэлгийн үзлэг, шинжилгээний зардал нь ялангуяа ядуу амьдралтай айлын хүүхдэд дaramт учруулж байна.

Хэргийг шалгах явцад хохирогч жирэмсэн болсон, бэлгийн замын халдварт өвчин туссан нь хожуу илэрч, бие махбодь, сэтгэл санаа, эрүүл мэндийн хувьд дахин хохирох, цаг хугацаа алдсанаас ураг хөндүүлэхэд хохирогчийн амь насанд аюултай нөхцөл байдал бий болсон тохиолдол гарч байлаа.

Бэлгийн замын халдварт өвчний оношилгоо, шинжилгээ үнэ төлбөргүй хийгдэж байгаа боловч эмчилгээ нь төлбөртэй, ялангуяа өвчин хүндэрсэн байх тусам илүү өндөр өртөгтэй болдог нь хохирогчийг давхар дaramтанд оруулж байна. Иймд хохирогч хүүхдийн шүүх эмнэлгийн зардал, эрүүл мэндэд учирсан хор уршгийг арилгах, нөхөн үржихүйн шаардлагатай тусlamж, үйлчилгээ, нөхөн сэргээх үйлчилгээг төрөөс үнэ төлбөргүй үзүүлдэг болгох шаардлагатай юм.

Мөрдөн байцаалтын шатанд хэргүүдийг шалган шийдвэрлэж байгаа дундаж хугацаа 5 сар байгаа нь хохирогчийн хувьд урт байна. Энэ хугацаанд холбогдгчийн ар гэрийнхэн хохирогчийг дaramтлах, айлган сүрдүүлэх зэргээр нөлөөлж, хүүхэд байцаан шийтгэх ажиллагаанаас залхах, улмаар бусдын ятгалгад орж мэдүүлгээсээ буцах боломжийг бүрдүүлж байна.

“БЭЛГИЙН МӨЛЖЛӨГ, ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДИЙН ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ НЬ”

Энэ төрлийн хэргийг аль болох хялбаршуулсан журмаар шийдвэрлэх практик алхамууд бий болгох нь чухал байна.

Эрэгтэй хүүхдийг “эмэлсэн” буюу хүчирхийлсэн кейсийг тухайлан судлахад асуудлыг шалгах явцдаа баримтжуулж чадаагүйгээс гэмт этгээдэд ял завшуулжээ. Энэ хэргийг “бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах”-аар зүйлчлэн эрүүгийн хэрэг үүсгэж шалгасан боловч хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн байна. Хохирогч бие махбодийн гэмтэл авснаас гадна хувийнх нь нууцлал алдагдаж, хэт олон хүн энэ тухай мэдсэнээс шалтгаалан сэтгэл санааны давхар хохирол амсчээ.

3.2. Шүүхийн шат

Шүүх хурлын тэмдэглэл, мөрдөн байцаалтын явцад бэхжүүлэн авсан мэдүүлгүүдтэй танилцахад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нарын зүгээс хохирогчийг “хөнгөн явдалтай” хэмээн буруутгах хандлага ажиглагдсан ба “Чи өөрөө дуртайдаа очиж хүчиндүүлээд байсан юм биш үү?” гэж асуусан байдаг. Энэ нь хохирогчийн хуулийн байгууллагад итгэх итгэлийг алдагдуулахад хүргэжээ.

Шүүх хуралдааны үед хохирогч сэтгэл санааны хямралтай байсаар атал түүнийг тусгаарлах арга хэмжээ авахгүй байгаа нь хүүхдийн сэтгэл санааны хямралыг даамжуулахад нөлөөлж байна.

Мөн тодорхой кейст бэлгийн мөлжлөгт өртөж сэтгэл санаа, бие махбодийн хувьд хохирол хүлээсэн хүүхэд ямар нэг дарамт шахалт дор, өөрийгөө хамгаалах чадваргүй байдлын улмаас гэмт хэрэг үйлдсэн байж болохыг¹² анхаарч үзээгүй ял ногдуулсан нь гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн шалтгаан нөхцлийг бодитой тогтоож, энэхүү нөхцөл байдлыг харгалзаж шийдвэрлэж байх шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүргэв.

3.3. Хохирогч хүүхдийг хамгаалах асуудлаар практикт тулгарч буй бэрхшээл

Хуулийн байгууллагын ажилтнуудын хохирогчийг буруутган үзэх хандлага

Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн хохирогч хүүхдүүдийн зан үйлд гардаг сөрөг өөрчлөлтийн нэг нь биеэ үнэлэхэд татагдан ордог явдал. Энэ нь гэмт этгээдүүдэд хөнгөн зууш болж, тэдний хүсэл зоригийн эсрэг хүчээр биеийг нь үнэлүүлж, бэлгийн мөлжлөгт өртүүлэх хамгийн гол эрсдэлт хүчин зүйл болж байгааг хуулийн байгууллагын ажилтнууд анхааралтай авч үзэх ёстой. Гэтэл хохирогчийг “биеэ үнэлэгч” гэж буруутган, нэгэнт биеэ үнэлэгч болсон хүүхэд бэлгийн хүчирхийлэл мөлжлөгт өртөх нь зүй ёсны хэрэг, байх ёстой зүйл мэт үзэж, энэ үзэгдэлтэй эвлэрэх хандлага хуулийн байгууллагын ажилтнуудын дунд тогтсон байна.

¹² Судлагдсан кейст хохирогч өөрөө эмзэг байдлынхаа улмаас хулгайн гэмт хэрэгт холбогдох улмаар шүүхээс хорих ялаар шийтгүүлж, эмэгтэйчүүдийн хорих ангид ял эдэлж байгаа жишээ байна.

“БЭЛГИЙН МӨЛЖЛӨГ, ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДИЙН ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ НЬ”

Мөрдөн байцаалт явуулж байгаа орчин

Мөрдөн байцаалтын шатанд хохирогчдоос мэдүүлэг авах тусгай өрөө байхгүй, хохирогчийг хулгай, дээрэм, хүчингийн гэх мэт янз бурийн гэмт хэрэгүүлдсэн этгээдүүдтэй нэг өрөөнд байцааж байгаагаас хохирогч хүүхдийн анхаарал сарних явдал их гарч байсан төдийгүй хохирогчийн хувийн нууцлал алдагдах, ичгүүртэй байдалд орох, улмаар мөрдөн байцаалтаас зугатахад хүргэж байлаа. Ихэвчлэн охид өртдөг бэлгийн мөлжлөг, хүчирхийллийн хэргүүдийг шалгах мэргэшсэн эмэгтэй мөрдөн байцаагч байхгүй, зарим дүүрэгт хохирогчийг байцаах зориулалтаар тусгайлан тохижуулсан өрөө нь хүүхдийн байцаагч эсвэл өөр алба хаагчийн тасалгаа болон ашиглагдаж байлаа.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад мөрдөн байцаагч олон дахин солигдож байгаа нь хэргийг шалгах явцыг сунжуулах, хохирогчоор өөрт нь тохиолдсон таагүй үйл явдлыг ахин давтан яриулж сэтгэлийнх нь шархыг сэдрээн хямралд оруулах сөрөг нөлөөллийг үзүүлж байна.

Сэтгэл санааны хохирлыг үнэлэх, хэмжих аргачлал байхгүй

Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдэд эдийн гэхээсээ илүү эдийн бус гэм хор учирдаг. Өөрөөр хэлбэл, сэтгэл санааны хүчтэй цочролд орох, амиа хорлохыг оролдох, амиа хорлох зэрэг үр дагавар хүлээж байдаг. Сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх практик аргачлал, шүүхийн хэвшүүлэлт байхгүй зэрэг нь хохирогчийг хамгаалахад тулгарч буй хамгийн хүндрэлтэй асуудал юм. Үүгээрээ энэ гэмт хэргийн нийгмийн хор уршиг тодорхойлогдож байдаг. Гэтэл сэтгэл санааны хохирлыг тодорхойлох, хэмжих, үнэлэх, нөхөн төлүүлэх аргачлал байхгүй байна.

Хохирогчид учирсан гэм хорын болон сэтгэл санааны хохирлыг шүүх иргэний журмаар жич нэхэмжлэн гаргуулахыг тогтоолдоо дурьдаад өнгөрөх биш, эрүүгийн хэрэгтэй нь хамтатган шийдвэрлэж байх шаардлагатай.

Хохирогч хамгааллын зохицуулалт

Төслийн багийн ажилласан хэргүүд дотор хохирогчийн эмзэг байдалтай холбоотойгоор үйлдэгдсэн хэргүүд нилээдгүй байлаа. Хохирогчийн “эмзэг байдал” гэдэгт хамаатан садны дэмжлэг туслалцаа байхгүй, танил нөхдийн холбоо сүлжээгүй, хэт итгэмтгий, түүнчлэн эцэг эхийн хайр, халамж дутсан, гэр булийн хүчирхийллийн улмаас орон гэрээсээ дайжсан, хараа хяналтгүй, гудамжны тэнэмэл амьдрал зэрэг шинжүүд багтана.

Хохирогч болсон төлбөрийн чадваргүй хүүхдэд өмгөөлөгч томилдоггүйгээс эрх зүйн туслалцаа авч, зөрчигдсөн эрхээ хамгаалуулах боломжгүй байдалд хүргэж байна.

Эн нь бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртөж хохирогч болсон насанд хүрээгүй эмзэг хохирогчдыг дахин гэмт халдлагад өртөхөөс хамгаалах, нөхөн сэргээх, эрх зүйн үнэ төлбөргүй туслалцаа авах боломжийг нь хуульчилж өгөх хэрэгцээтэй байгааг харуулж байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ДҮГНЭЛТ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ

4.1.Үйл ажиллагааны хүрээнд өгөх дүгнэлт

- “Насанд хүрээгүй хүнийг биеэ үнэлэхэд татан оруулсан” гэмт хэргийн цаана хүүхдийг бусдад худалдах, дамжуулан худалдах гэмт хэрэг далдлагдаж байна.
- Насанд хүрээгүй хүүхдийг бэлгийн мөлжлөгт өртүүлсэн, хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг агуулсан ноцтой үйлдэлд хохирогчийг өөрийг нь “биеэ үнэлэгч” гэж буруутган, гэм буруутай этгээдийг Захиргааны хариуцлагын тухай хуулиар торгоод өнгөрөөх явдал гарсаар байна.
- Бэлгийн мөлжлөгт өртсөн насанд хүрээгүй хохирогчдод Захиргааны хариуцлагын тухай хуулиар шийтгэл хүлээлгэж байгаа нь тэдний хуулийн байгууллагад итгэх итгэлийг алдагдуулж, улмаар цагдаагийн байгууллагад хандахаас татгалзахад хүргэж байна.
- Захиргааны зөрчлийг гэмт хэрэгтэй ижил байдлаар хуульчилж, хэм хэмжээний давхардал үүсгэж байгаа нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд бэрхшээл учруулж байна. Улсын дээд шүүхийн тайлбарт “эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол” гэсэн ойлголт хэт бүрхэг байгаа нь хууль хэрэглэж, хэрэг маргааныг шийдвэрлэхэд сөргөөр нөлөөлж байна.¹³
- Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны шат дамжлага удаан, хохирогч гомдолтой гэсэн тохиолдолд хохирлоо нөхөн төлүүлж чадах эсэх нь эргэлзээтэй учраас хохирогч хохирлын мөнгө гэж хэдэн төгрөг аваад гомдоосоо буцахад хүрч байна.
- ЭБШХ-ийн 25 дугаар зүйлд зөвхөн хөнгөн гэмт хэргийг хуульд заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болгодог бөгөөд бусад төрлийн гэмт хэргийн хувьд хэрэгсэхгүй болгох боломжгүй юм. Гэтэл бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн хэргийг шалгаж, шийдвэрлэх явцад “хохирогчийн ар гэрийнхэнтэй нь эвлэрсэн” гэсэн үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгож хууль зөрчих явдал гаргаж байна.
- Мөрдөн байцаалт явуулж байгаа орчин, нөхцөл нь хохирогчийн нууцлал, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байна.
- Эрүүгийн байцаан шийтгэх хуульд “Насанд хүрээгүй гэрч, хохирогчийг байцаах” талаар тусгайлсан бүлэг одоогоор байхгүй, зөвхөн насанд хүрээгүй гэрч, хохирогчийн мэдүүлгийг шүүх ажиллагааны үед сонсох талаар л заажээ¹⁴. Харин 145 дугаар зүйлд заасан Насанд хүрээгүй гэрчийг байцаах зохицуулалт нь “хохирогч хамгаалал”-ын үйл ажиллагаатай төдийлэн хамааралтай биш байна.
- Мөрдөн байцаалт, шүүхийн шатанд хохирогчийг хөндрөнгийн нөлөөллөөс хамгаалах хуулийн арга хэрэгсэл байхгүй, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нарын ажил дүгнэх үзүүлэлтэд нь ордоггүй учир тэд ийм асуудалд “хуулиар хүлээсэн үүрэгт ажил биш” гэж хүнийрхсэн байдлаар хандаж байна.

¹³ ХЗҮХ., “Эрүүгийн болон Захиргааны хариуцлагын тухай хуулийн хэрэгжилт” судалгааны тайллан. 2007 он

¹⁴ ЭБШ хуулийн 269 дүгээр зүйл

“БЭЛГИЙН МӨЛЖЛӨГ, ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДИЙН ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ НЬ”

- Бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгийн хохирогч хүүхдийн аюулгүй байдлыг хангах, нөхөн сэргээх, эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагууд тогтвортой санхүүжилтийн эх үүсвэргүй, гаднын байгууллагын санхүүжилтээр үйл ажиллагаа явуулж байна.
- Төслийн багийн сайн туршлага нь эрүүгийн шүүхээс хохирогчид сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх талаар шийдвэр гаргуулж чадсан явдал байлаа. Бага насны хоёр хохирогчид сэтгэл санааны хохирол хүлээсэн гэж үзэж болох нотлох баримтыг бүрдүүлэн, шүүхэд итгүүлж чадсанаар тус бүр 2 сая төгрөг¹⁵ гаргуулж олгуулахаар эрүүгийн хэрэгтэй нь хамт шийдвэрлүүлжээ.

4.2. Эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох санал

- “Хүчиндэх” гэмт хэргийн ойлголтыг өргөжүүлж, төрөлжүүлэх;
- Хүчиндэх болон түүнтэй ойролцоо төрлийн гэмт хэргийн ялгаа, түүнийг зөв зүйлчлэх талаар УДШ-ээс дэлгэрэнгүй тайлбар гаргах;
- Гэмт хэргийн хохирогчид учирсан сэтгэл санааны хохирлыг хэмжих, тооцох, нөхөн төлүүлэх аргачлал боловсруулж, мөрдүүлэх;
- Эрүүгийн хууль, Садар самуун явдалтай тэмцэх тухай, Захиргааны хариуцлагын тухай, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиудын давхардлыг арилгах;
- Монгол Улсын Эрүүгийн хуулийн 122 дугаар зүйл (16 насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдэх) -ийг нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэн “Насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдэх” болгон өөрчлөх;
- Тодорхой судалгаа, шинжилгээний үндсэн дээр насанд хүрээгүй гэрч, хохирогчийг байцаах тухай тусгайлсан бүлгийг Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмж оруулах;
- Эрүүгийн байцаан шийтгэх хуульд албадлагын арга хэмжээний төрөл болгон хохирогчтой “улзахыг түр хугацаагаар хязгаарлах” арга хэмжээг оруулах;
- Хохирогч, гэрчийн аюулгүй байдлын хамгааллын асуудлыг ЭБШ хуульд тусгаж өгөх. Хохирогч, гэрчийг хамгаалах нь ЭБШ ажиллагааг хэрэгжүүлэгч (хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор шүүгч)-дийн үүрэг байхаар хуульчилж өгөх;
- Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн хохирогч хүүхдийг хамгаалах, эрүүл мэнд, сэтгэл засал, нөхөн үржихүйн болон нийгмийн бусад үйлчилгээг хүргэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох. Тухайлбал,
- Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн “хүнд нөхцөлд байгаа хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээний төрөл”-д эрх зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээг нэмэх;
- Эрүүл мэндийн тухай хууль, Нийгмийн халамжийн хууль, Эрүүл мэндийн даатгалын хуулиудад “бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд төлбөргүй үзүүлэх үйлчилгээ”-г нарийвчилсан судалгааны үндсэн дээр тусгаж өгөх.

15 2010 оны 2 сарын 5-ны өдрийн СХД-ийн шүүхийн №67 дугаар шийтгэх тогтоол

4.3. Хуулийн байгууллагын үйл ажиллагаанд өгөх зөвлөмж

- Насанд хүрээгүй хүний хувьд “биеэ үнэлэлт” гэсэн ойлголт байх боломжгүй. Энэ нь бэлгийн хүчирхийллийн үр дагавар учир ийм тохиолдол бүрийг нарийвчлан судалж үзсэний үндсэн дээр шалтгаан, нөхцлийг тогтоож, цаана нь байгаа гэмт этгээдүүдийг эрүүгийн хэрэгт заавал татан шалгаж байх;
- Бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд өртсөн хохирогчдоос байцаалт авах тусгай өрөөг аймаг, дүүргийн цагдаагийн хэлтэс, газар, УМБГ-т ажиллуулах;
- Хүүхдийн эсрэг хүчирхийллийн хэрэгтэй ажиллах мэргэшсэн эмэгтэй мөрдөн байцаагчдыг бэлтгэж, ажиллуулах;
- Насанд хүрээгүй хохирогчдод өмгөөлөгч томилуулах хүсэлтийг Монголын өмгөөлөгчдийн холбоонд тухай бүр тавьж байх;
- Ураг төрлийн хүчингийн гэмт хэргийн хохирогчийг хамгаалахын тулд хүчирхийлэл үйлдсэн этгээдэд Гэр булийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн эрх хязгаарлах арга хэмжээний төрлүүдээс авахуулах хуулийн боломжийг ашиглаж хэвших;
- Хуульчдын дунд тогтсон насанд хүрээгүй хүний биеэ үнэлэлтийг “хүлээн зөвшөөрөх” хандлагыг өөрчлөх сургалтуудыг явуулах.

4.4. Хохирогчийг нөхөн сэргээх, нийгмийн ажил, үйлчилгээг сайжруулах талаарх зөвлөмж

- Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан Нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмжийг өнөөгийн нөхцөл байдалд тохируулан хүүхдийн эрхийг хамгаалж буй төрийн бус байгууллага мөн адил авах эрхтэй байхаар өөрчлөн найруулах;
- Хүүхдийг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлд төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах;
- Хүүхдийг бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах, урьдчилан сэргийлэх, хүчингийн гэмт хэргийг олон нийтэд жигшүүлэх ажиллагаа хийлгэж, тэдний ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх, олон нийтэд чиглэсэн сургалт сурталчилгааны ажлыг тасралтгүй хийх.

ТАВДУГААР БҮЛЭГ

БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ, МӨЛЖЛӨГТ ӨРТСӨН
ХҮҮХДИЙН ЗӨРЧИГДСӨН ЭРХИЙГ СЭРГЭЭХ ТАЛААР
ӨМГӨӨЛӨГЧ, МӨРДӨН БАЙЦААГЧИД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

5.1. Өмгөөлөгчдөд зориулсан зөвлөмж

Бэлгийн мөлжлөг, хүчирхийллийн гэмт хэргийн нотлогдвол зохих байдлууд, түүний хэмжээ хязгаар

Гэмт хэрэг бүрийн онцлогоос шалтгаалан хэрэг тус бүрийн нотлогдвол зохих байдлуудын бүрэн жагсаалтыг хуульчлах боломжгүй, өөрөөр хэлбэл нотолгооны зүйлийг хуульд тодорхойлж болдог бол хэмжээ хязгаарыг тогтоож болдоггүй.

Гэмт хэргийн нотолгооны хязгаар гэдэг нь гэмт хэргийн нотолгоо явагдах цар хүрээг илэрхийлдэг бол нотолгооны хэмжээ гэдэг нь тухайн асуудлыг хангалттай нотлохын тулд хэдий хэрийн баримт сэлт, мэдээлэл цуглуулбал зохих ёстойг илэрхийлж байгаа үзүүлэлт юм.

Өмгөөлөгч нь эрүүгийн хэрэгт оролцох явцдаа нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх ажиллагаанд идэвхтэй хэлбэрээр оролцож болох хэд хэдэн арга байдаг. Энэ нь “хуулиар хориглоогүй бусад арга” гэсэн ойлголтонд ордог бөгөөд хүний нэр төр, алдар хүндэд харшилсан, хууль бусаар олж авсан шинжгүй байх ёстой гэдгийг онцгой анхаарвал зохино. Үүнд:

1. Цагдаагийн байгууллагад хандахаас өмнө хохирогч өөрөө үйлчилгээ үзүүлэгч байгууллагад хүргэгдэж ирсэн үед анхны мэдээлэл, бодит нөхцөл байдлыг нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нарын оролцоотойгоор бэхжүүлж авах. Ингэхдээ дүрс бичлэгийн болон гэрэл зургийн аппарат ашиглаж болно. Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын гол алдаа бол “анхны үйлчилгээ үзүүлсэн баримт нотлох баримт болохгүй байх” гэсэн хандлагаар баримтжуулалтыг дутуу хийдэг явдал юм. Өмгөөлөгчөөс дээрх баримтыг нотлох баримтын хэмжээнд цуглуулах, бэхжүүлэх тухай хүсэлт гарган шийдвэрлүүлж хэвших хэрэгтэй¹⁶. Энэ нь байцаан шийтгэх ажиллагааны журамд харшлахгүй бөгөөд бэхжүүлж авахдаа өөрсдөө тэмдэглэл үйлдэх, эсвэл хураан авах замаар нотлох баримтын хэмжээнд бэхжүүлж болно¹⁷
2. Тодорхойлолт авах: Өмгөөллийн тухай хуульд¹⁸ зааснаар өмгөөлөгч бусад байгууллагаас тодорхойлолт гаргуулан авах эрхтэй байдаг. Энэхүү гаргасан тодорхойлолт хэрэг шийдвэрлэхэд ач холбогдолтой гэж үзэж байвал хэрэгт хавсаргах, бэхжүүлж авах тухай хүсэлтийг мөн бичгээр гаргаж хэвших хэрэгтэй

¹⁶ Өмгөөллийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.4-т “өмгөөлөгч нь нотлох баримт гаргаж өгөх, шинэ нотлох баримт шаардах буюу хэрэгт ач холбогдол бүхий бусад байдлыг шалгуулах, шинжээчийн дүгнэлт гаргуулах санал хүсэлт тавих эрхтэй” гэжээ.

¹⁷ Мөрдөн байцаагч нартай хийсэн ярилцлагын дүн, 2010 он

¹⁸ Өмгөөллийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Өмгөөлөгч мэргэжлийн үүргээ биелигүүлэхэд зайлшигүй шаардлагатай баримт бичиг, мэдээ сэлтийг гаргуулан авахын тулд шүүх, прокурор, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллага, бусад байгууллага, түүний холбоодох албан тушаалтанд хүсэлт гаргах эрхтэй”

“БЭЛГИЙН МӨЛЖЛӨГ, ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДИЙН ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ НЬ”

бөгөөд энэ нь нотлох баримтын ач холбогдлыг нэмэгдүүлдэг. Тухайлбал, хохирогч мэс засал хийлгэсэн, сэтгэл заслын үйлчилгээ авсан эсвэл хүчиндүүлснээс шалтгаалан жирэмсэлж, ураг хөндүүлэх, амь насанд аюултай эмчилгээ хийлгэсэн үед өвчтөний түүхийн хуулбарыг гаргуулан авах, эмнэлгээс нь өвчний шинж тэмдэг, бусад байдлын талаар тодорхойлолтыг гаргуулан авч мөрдөн байцаагчаар тэмдэглэл үйлдүүлэн хэрэгт хавсаргах гэх мэт хэлбэртэй байж болно.

3. **Гэрч, мэргэжилтний хувиар сэтгэл зүйч, нийгмийн ажилтныг байцаан шийтгэх ажиллагаанд оролцуулах:** Хүүхдэд үйлчилгээ үзүүлсэн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нь мөрдөн байцаагчид хүүхдэд учирсан тодорхой бэрхшээлийг тодруулах, хэрэгт ач холбогдол бүхий баримтыг бэхжүүлэхд туслалцаа үзүүлэх нь хэргийн шийдвэрлэлтэнд шууд нөлөөлдөг. Нэн ялангуяа кейс шийдвэрлэлтийн явцад ийм байдлаар байцаан шийтгэх ажиллагаанд оролцож байгаа явдал нь ихээхэн үр дүнтэй нь мэдрэгдэж байсан.
4. Нотлох баримтыг цуглуулах үед анхаарах асуудлууд: Θмгөөлөгч нь ЭБШХ-д зааснаар нотлох баримтыг цуглуулах эрх бүхий этгээд биш тул үүрэгт ажлаа гүйцэтгэх явцад олж мэдсэн мэдээлэл, баримт сэлтээ цагдаагийн байгууллагад гарган өгч байгаа тэр хэлбэрээр хандах нь үр дүнтэй. Доорхи зүйлсийг анхаарах шаардлагатай:
 - Болсон үйл баримт, фактыг үнэн зөв, бүрэн тодорхой тусгах;
 - Нотлох баримт болохуйц зүйлсийг үрэгдэх, гэмтэх, солигдохоос сэргийлж гэрэл зургаар бэхжүүлэх, лацах, шинж тэмдэг, онцлог зүйлийг тэмдэглэж авах, хувилж авч болох бол хувилж авах гэх мэт дараа нь гомдол, хүсэлт гарган шийдвэрлүүлэх баримттай байх;
 - Хэрэгт цаашид ач холбогдолтой баримт сэлт, мэдээллийг шалгах бололцоог бий болгох шаардлагуудыг баримталбал зохино. Ингэхдээ нотлох чадвараа алдаж болзошгүй нөхцөл байдлыг анхаарах хэрэгтэй.
 - **Хувийн нууцыг хамгаалах:** Төслийн багийн гишүүдээс хэргийг шийдвэрлэх явцад гарч байсан бэрхшээлтэй нэг асуудал бол тухайн хохирогчийн хувийн нууцлал бүхий баримтыг задруулах явдал байлаа. Нэн ялангуяа байцаан шийтгэх ажиллагаанд гэрч, сэжигтний хувиар байцаагдаж байгаа этгээд хохирогчийн “хувийн нууцыг задруулна” хэмээн айлгаж сурдуулэх явдал нэг бус удаа гарч байсан бөгөөд эдгээр тохиолдол тухай бүрт нь үр дүнтэй арга хэмжээ авч хэвшүүлэх хэрэгтэй байна. Тухайлбал, гэмт хэргийн хохирогчийн хувийн нууцтай холбоотой асуудал нь мөрдөн байцаалтын нэг хэсэгт хамаардаг учир “байцаан шийтгэх ажиллагааны журам зөрчсөн” хэмээн тухайн мөрдөн байцаах албаны дарга болон шүүгчид хүсэлт гарган шийдвэрлүүлж болно.¹⁹
5. **Хүсэлт гаргах:** Θмгөөллийн тухай хууль болон ЭБШХ-иар өмгөөлөгчид олгосон үйл ажиллагааны эрх зүйн хэлбэр, боломж нь хүсэлт гаргах эрх юм. Хүсэлт гаргах эрх нь өөрийн үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах, гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдал, шалтгаан, түүний улмаас учирсан хохирлыг бодитой тогтоох талаар байж болно.
6. **Гэмт этгээдээс сэтгэл санааны хохирол нэхэмжлэн гаргуулах:** Эрүүгийн хэрэг

¹⁹ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 77, 78 дугаар зүйлд байцаан шийтгэх ажиллагааны журам зөрчсөн тохиолдолд тorgууль ногдуулж болох эрх зүйн үндэслэлийг дурдсан бөгөөд энэ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1-4 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр тorgохоор заасан.

“БЭЛГИЙН МӨЛЖЛӨГ, ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДИЙН ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ НЬ”

дэх иргэний нэхэмжлэлд өмгөөлөгч анхааралтай хандах ёстой. ЭБШ ажиллагааны явцад гэмт хэргийн улмаас хохирогчид учирсан гэм хорын хохирол болон сэтгэл санааны хохирлын талаарх нотлох баримтыг бүрдүүлэхэд нь хохирогчид зөвлөх, туслах, нэхэмжлэлийг нь дэмжих хэлбэрээр оролцож болно.

Сэтгэцийн гэм судлаач-шинжээчээр хохирогчийн сэтгэл санааны хохирлын зэргийг тогтоолгож¹, түүнийг эмчлэх хугацаанд гарах зардлыг тооцон нотлох баримтын хэмжээнд бүрдүүлж иргэний нэхэмжлэлд хавсаргах боломжтой юм.

Гэм буруутай этгээдээс сэтгэл санааны хохирлыг “Амьжиргааны баталгаажих доод түвшин”-тэй уялдуулан нэхэмжлэх боломжтой. Энэ нь хохирогч ажил хөдөлмөр эрхлээгүй, орлогогүй нөхцөлд амьдрахын тулд зайлшгүй шаардагдах зүйлийн мөнгөн илэрхийлэл юм.

7. Насанд хүрээгүй хохирогчийг байцаах, эрүүгийн байцаан шийтгэх тодорхой ажиллагаанд оролцуулахад бичлэг хийлгэх, түүнчлэн тухайн хэрэгт хяналт тавьж байгаа прокурорыг байлцуулах нь ихээхэн үр дүнтэй юм. Энэ нь хэргийн шийдвэрлэлтэд шууд нөлөөлдөг давуу талтай.
8. ТББ-д ажиллаж буй, хуульч өмгөөлөгчид нь нийгмийн ажилтан, сэтгэл зүйчидтэй хамтран ажиллах: ТББ-уудын сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, өмгөөлөгчидтэй хамтран ажиллах боломжтой. Мөн төрийн бус байгууллагууд нь эрх ашгаа хамгаалуулж буй хохирогчдоо байцаан шийтгэх ажиллагааны явцад мэдүүлэг өгүүлэхдээ цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах үндсэн дээр мөрдөн байцаагчийг хохирогч байгаа газар /боломжтой бол энгийн хувцастай/ ирүүлж ажиллагаа явуулах, өөрсдөө байлцах тал дээр санаачлагатай ажиллах хэрэгтэй байна. Энэ нь нотлох баримтыг шүүх үнэлэхэд өндөр ач холбогдолтой байхыг угүйсгэхгүй.
- Хэдийгээр Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд хүүхдэд үзүүлэх тусlamж, үйлчилгээг зааж өгсөн боловч үүнд эрх зүйн тусlamж, үйлчилгээг орхигдуулсныг анхаарах.
9. **Байцаалтын явцад анхаарах зүйл:** Хохирогч, мөрдөн байцаагч хоёрын хооронд итгэлцэл, харилцан ойлголцлыг бий болгоход өмгөөлөгч анхаарах нь чухал.

5.2. Мөрдөн байцаагчдад зориулсан практик зөвлөмжүүд:

Хохирогчийг байцаах. Хохирогчийг байцаах нь мөрдөн байцаагч, өмгөөлөгчөөс ихээхэн ур чадвар шаардсан ажил байдаг. Ялангуяа бэлгийн мөлжлөгт өртсөн хохирогчид олонх тохиолдолд бие махбодь болон сэтгэл зүйн хүнд дарамтанд орсны улмаас айж эмээсэн, сэжиглэсэн байдалтай байдаг тул үнэн зөв мэдүүлэг өгөхгүй байх, мэдээллээ нуун дарагдуулах явдал гаргадаг. Сэтгэл зүйн хүнд дарамтад (Post Traumatic Stress Disorder) орсон хохирогчид:

- Айж эмээсний улмаас худал мэдүүлэг өгөх;
- Хохирогч болохоо угүйсгэх;
- Логик сэтгэн бodoх чадвараа алдаж үнэн зөв мэдүүлэг өгөх чадваргүй болох;
- Болсон явдлын талаар ой санамжaa алдах Г.М. шинж тэмдэг илэрдэг.

“БЭЛГИЙН МӨЛЖЛӨГ, ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДИЙН ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ НЬ”

Дээрх нөхцөл байдлын улмаас хохирогчийг таних, тэднийг гэрчээр татах, хууль сахиулах байгууллагын зүгээс хохирогчтой хамтран ажиллахад бэрхшээл тулгардаг.

Сэтгэл зүйн хүнд дарамтанд орсон хохирогчийг байцаах үйл явц дараах хоёр үе шаттай байна:

- 1) Сэтгэл зүйч, мэргэжилтний тусламжтайгаар хохирогчтой сэтгэл зүйн холбоо тогтоох, итгэл найдварыг нь төрүүлэх;
- 2) Тодорхой хэмжээгээр тайвширсны дараа хохирогчийг байцаах;

Хохирогч сэтгэл зүйн хувьд дарамтанд байгаа үедээ бэлгийн мөлжлөгт өртсөн хохирогч гэдгээ үгүйсгэх, нотлох баримтын эсрэг мэдүүлэх зэрэг тохиолдол гардгийг анхаарч, боломжтой бол мэргэшсэн сэтгэл зүйчийг байлцуулах хэрэгтэй юм.

Хохирогчийг байцаах нь хэргийг илрүүлэх нэг гол үе шат байдаг учраас дараах зөвлөмжийг дагаж мөрдөхөд анхаарах:

- Хэлмэрч: хохирогч байцаалт явагдах хэлээр хангалттай мэдлэггүй байгаа тохиолдолд хэлмэрч оролцуулах;
- Сэтгэл зүйч: хохирогч сэтгэл зүйн хувьд мэдүүлэг өгөхөд бэлэн бус байгаа нөхцөлд мэргэшсэн сэтгэл зүйчийг байлцуулах;
- Хуулийн зөвлөх: Хохирогчоос байцаалт аваадаа боломжтой бол хохирогчийн багш, сурган хүмүүжүүлэгч, эсвэл ойр дотных нь хүн, хамаатан садан эсхүл түүнийг дэмжих байгууллагаас хуулийн зөвлөх оролцуулах.

Бэлгийн мөлжлөгт өртсөн хохирогчийг байцаахын өмнө дараах журмыг мөрдөх нь чухал юм.

Бэлтгэл ажил:

- Чимээ шуугиангүй, бусад хүмүүст саад болохооргүй өрөө сонгох;
- Зөвхөн хохирогч, мөрдөн байцаагч, шаардлагатай тохиолдолд хэлмэрч, хууль зүйн болон сэтгэл зүйн зөвлөхийг оролцуулахаар тохиролцох;
- Гар утсаа унтраасан байх;
- Зориулалтын байр олдохгүй бол бусад хүмүүст яриа сонсогдоооргүй газар байцаах хүсэлт гаргах.
- Хэрэв хохирогч эмнэлгийн тусламж авах шаардлагатай байгаа бол байцаалтыг хойшилуулж, эмнэлгийн мэргэжилтнээр үзлэг хийлгэх;

Танилцуулах

- Хохирогч тайван, тав тухтай байгаа эсэхийг мэдэх, ариун цэврийн өрөө орох болон ямар нэг зүйл хүсэж буй эсэх, биеийн байдал нь хэвийн, эмнэлгийн тусламж авах шаардлагатай эсэхийг асууна.

“БЭЛГИЙН МӨЛЖЛӨГ, ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДИЙН ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ НЬ”

Тайлбарлах

- Асуултад тайван хариулж, хүссэн үедээ завсарлага авах боломж;
- Асуултыг ойлгохгүй бол давтан тайлбарлуулах;
- Асуултад хариулахад татгалзах зүйл байгаа эсэхийг асууж тайлбарлана.

Насанд хүрээгүй хохирогч нь олон дахин давтагдсан зүйлийг төдийлөн сайн санахгүй, ихэвчлэн барагцаагаар хэлдэг. Тиймээс амралт, баяр ёслол, тэмдэглэлт өдрүүд зэрэг хохирогчийн санаанд сайн үлдэж болох цаг хугацааг сануулж өгөх аргыг²⁰ байцаалтын үед ашиглавал үр дүнтэй байдаг.

Хохирогч хүүхэдтэй ажиллах, хувийн байдлыг тогтоох:

Бэлгийн мөлжлөг, хүчирхийллийн хохирогч хүүхдийг анх байцаахдаа түүний талаар товч танилцуулга, болсон үйл явдлын тухай маш товчхон яриулах төдийгээр хязгаарлах хэрэгтэй. Хүүхдийг байцаах нь өндөр ур чадвар шаардсан ажил тул эхний байцаалтаар энгийн асуултууд тавих ба бэлгийн мөлжлөг, хүчирхийллийн хохирогч мөн байж болзошгүй гэдэг ойлголтод хүрээд асуултыг хязгаарлах хэрэгтэй.

Бэлгийн мөлжлөгийн хохирогч хүүхдүүд насанд хүрсэн хүмүүсийг бодвол сэтгэл зүйн хувьд илүү хүнд байдалд байдаг тул асуултад хариулах, мэдээлэл өгөх дургүй байх хандлагатай байдаг. Түүнчлэн буруу асуулт тавьснаар тэдний сэтгэлийн шархыг сэдрээж улам хүнд байдалд оруулах талтайг анхаарах нь зүйтэй.

Үүний дараа хохирогч хүүхдийг хохирогчид тусламж үзүүлэх төвд шилжүүлж мэргэшсэн хүмүүсийн асрамжид байлгах, мөн хүүхдийг асран хамгаалах байгууллага, албан тушаалтанд хандах нь зүйтэй.

Хохирогчтой хийсэн ярилцлагыг баримтжуулах, мэдүүлэгт зайлшгүй тодруулах зүйлүүд:

- Хохирогч амиа хорлох оролдлого болон эрх зүйн зөрчил, зан үйлийн гаж өөрчлөлт, үйлдэл хийж байсан эсэх талаар;
- Бага насны хохирогчийн хувьд амьдралын хэвийн маяг нь алдагдаж ааш занд нь ноцтой өөрчлөлт орсон байдал;
- Ангийн багш, ойр дотно үерхдэг найз нөхөддөө хэлсэн байдал;
- Бусад.

Цагдаагийн байгууллагын болон засаг захиргааны анхан шатны байгууллагаас тодруулах зүйл:

- Сэжигтэн гэр орондоо хүчирхийлэл үйлдэж байсан эсэх, удаа дараа эрүүлжүүлэгдэж байсан буюу захиргааны арга хэмжээ авагдаж байсан талаар хорооных нь хэсгийн байцаагчаас мэдээлэл авах;
- Захиргааны журмаар арга хэмжээ авагдаж байгаагүй боловч байнгын хүчирхийлэл, дарамтанд байсны улмаас хорооны цагдаад дуудлага өгч, гомдол гаргаж байсан талаар мэдээлэл авах;
- Гэр бүлд нь байнгын хүчирхийлэл буюу зөрчил маргаантай байдаг эсэх талаар хорооны Засаг дарга, нийгмийн ажилтнаас мэдээлэл авах;
- Бусад

20 Үүнийг мөрдөн байцаалтын тактикт “хронологийн арга” хэмээн нэрлэдэг.

“БЭЛГИЙН МӨЛЖЛӨГ, ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДИЙН ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ НЬ”

Өрхийн эмч болон бусад эмнэлгийн байгууллагаас мэдээлэл авах

- Өрхийн эмчийн тэмдэглэл;
- Өвчний онош, эмчилгээ бичсэн карт;
- Эмчийн болон эмнэлгийн байгууллагын дүгнэлт.

Эмнэлгийн байгууллагын бэртэл, гэмтлийг тогтоосон дүгнэлт

- Шүүх эмнэлгийн гэмтлийн зэргийг тогтоосон дүгнэлт;
- Бэлгийн хүчирхийллийн хохирогчид уулгаж байсан эм /жирэмснээс хамгаалах/;
- Үр хөндөлт хийсэн эмчийн тэмдэглэл.

Шүүх сэтгэц гэм судлал, наркологийн төвийн дүгнэлт

- Хүчирхийлэл дарамтад байнга байсны улмаас сэтгэцийн өөрчлөлтэй болсон эсэхийг тогтоосон дүгнэлт;
- Мансуруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл хэрэглэж байсан эсэх.

Бэртэл гэмтлийн байдлыг фото зургаар баримтжуулах:

- Анагаах ухааны хэллэгээр ямар, ямар бэртэл гэмтэл учирсан талаар бичиж, баримтжуулах;
- Бэртэл, гэмтлийн байдлыг фото зургаар баримтжуулахдаа эхэлж заавал бүтэн биеэр нь зургийн нь авах, дараа нь тухайн бэртэж гэмтсэн газруудыг хэсэгчлэн авах;
- Бэртэл гэмтлийг фото зургаар бэхжүүлэхдээ хальсны аппаратаар бэхжүүлнэ. /Дижитал аппаратаар авсан зурагт засвар хийж болдог, гар утсаар авсан дүрс, дууны бичлэг нотлох баримтын хэмжээнд үнэлэгддэггүй гэдгийг анхаарах/;
- Баримтжуулалт хийсэн, хохирогчийн биеийн аль хэсгийн гэмтлийг харуулсан хэдэн ширхэг зураг, хэдний өдөр баримтжуулж авсан зэргээ заавал бичиж, тэмдэглэж байх;
- Фото зургийг авсан он, сар, өдрийг зургийн аль нэг хэсэгт гаргаж байх.

Утсан холбоо болон мэдээллийн бусад хэрэгсэл ашиглан хүчирхийлэл үйлдсэн талаарх баримт

- Мессежээр заналхийлэх, дарамтлах, айлган сүрдүүлж байсан талаарх нотолгоог цуглуулах /утасны мессежийг фото зургаар бэхжүүлэх/;
- Хохирогчийн яриа болон цаанаас утсаар заналхийлж байгаа яриаг дүрс бичлэг болон диктелефоноор бичиж баримтжуулах;

Анхаарах зүйл: Нотолгоог баттай эх сурвалжаас хуулийн шаардлага хангасан хэмжээнд бүрдүүлэх нь чухал.

“БЭЛГИЙН МӨЛЖЛӨГ, ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДИЙН ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ НЬ”

Хавсралт 1.

Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн гэмт хэргийн хохирогч хүүхдийг нөхөн сэргээх үйлчилгээний эрх зүйн боломж

Энэхүү зөвлөмжийн хүрээнд бэлгийн мөлжлөгт өртсөн хохирогч хүүхдийн эрхийг Монгол Улсын Эрүүгийн хуулиас бусад хуулиар хамгаалах хууль зүйн боломжийн талаар авч үзсэн болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 11-т Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална;” гэж заасан нь хүүхдийн эрхийг хамгаалах суурь зохицуулалт юм. Тийм ч учраас хүүхдийн асуудлыг аливаа салбар эрх зүйд тусгайлан авч үзсэн байдаг.

Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа аливаа хуульд “бэлгийн мөлжлөг” гэж шууд заасан, тайлбарласан нэр томъёо байдаггүй бөгөөд одоогоор энэ ойлголтыг “хүнд нөхцөлд байгаа хүүхэд” гэсэн хууль зүйн ойлголттой адилтган хэрэглэж байна.

Бэлгийн мөлжлөгт өртөж хохирсон хүүхдийн “эрх, хууль ёсны ашиг сонирхол”²¹-ыг хамгаалахдаа дараах хүчин зүйлүүдийг зайлшгүй авч үзэх шаардлагатай:

1. эрүүл мэнд /бие махбодь, сэтгэл санаа/;
2. боловсрол /суурь боловсрол эзэмших харилцаагаар дамжуулж хэрэгцээтэй ерөнхий мэдлэгийг олж авдаг/;
3. гэр булийн болон амьдрах орчин /гэр бүл нь нийгмийн хамгийн анхдагч нэгж, хүний хамгийн чөлөөтэй байх орчин/;
4. бусад /эдийн болон эдийн бус хохирлыг тооцон гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх, “нийгэмшүүлэх” гэх мэт/.

Эдгээр хүчин зүйлсийг үндэслэл болгон дараах хуулиудыг сонгон авсан²².

1. Эрүүл мэндийн тухай хууль /1998 оны 5 дугаар сарын 7-ны өдөр/

35 дугаар зүйл. Эх, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах баталгаа

35.1. Монгол Улсад эх, хүүхдийн эрүүл мэнд төрийн байнгын анхаарал, ивээлд байна.

35.2. “Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас эх, хүүхдэд үзүүлэх эмнэлгийн мэргэжлийн тусlamж, үйлчилгээний төлбөрийг төр хариуцна.”

26 дугаар зүйлийн 26.1.2 дахь заалт “гэнэтийн өвчин, осол, гэмтлээс амь насанд нь аюул үчирсан иргэн, амаржих гэж байгаа эхэд энэ хуулийн 25.1.3-т зааснаас бусад тохиолдолд эмнэлгийн тусlamжийг ямар ч нөхцөлд үзүүлэх;”

Хэдийгээр практикт зарим нэг хүндрэл, бэрхшээлтэй тулгарч байдаг ч хохирогч хүүхдийг үзлэг, шинжилгээ, эмчилгээ гэх мэт эрүүл мэндийн үйлчилгээнд холбохдоо хуулийн энэ зохицуулалтыг аль болох ашиглах оролдлого хийх нь зүйтэй.

²¹ Эрх, хууль ёсны ашиг сонирхол гэдэгт хүүхдийн баталгаатай эдлэх эрх, бусад хуулиар олгогдсон субъектив боломж юм./Судлаач/

²² Холбогдох бусад хуулиуд байгаа боловч өмнө нь энэ сэдвээр хийдсэн судалгаа, шинжилгээний ажилд хангальтай дурьдаадсан учир эдгээр хуулиудаар хязгаарласан болно./Судлаач/

“БЭЛГИЙН МӨЛЖЛӨГ, ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДИЙН ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ НЬ”

2. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль /1996 оны 5 дугаар сарын 7-ны өдөр/

15 дугаар зүйл. Онцгой ба хүнд нөхцөлд байгаа хүүхдэд үзүүлэх нийгмийн халамж, тусламж

2. Бүтэн өнчин, тахир дутуу, нэн ядуу, хараа хяналтгүй, садар самуун, хүчирхийлэл, доромжлолын улмаас сэтгэл санааны болон бие махбодийн хохирол хүлээсэн, эрүүл мэнд, амь насанд нь аюул учруулах хөдөлмөр эрхэлж буй хүүхдийг **хүнд нөхцөлд байгаа хүүхдэд гэж үзнэ**. Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол хүнд нөхцөлд байгаа хүүхдэд дараах халамж, хөнгөлөлт, тусламж үзүүлнэ:

1/ боловсрол, мэргэжил эзэмшихэд туслалцаа үзүүлэх;

2/ эрүүл мэндийг нь нөхөн сэргээх, сувилах, тахир дутуу хүүхдэд хиймэл эрхтэн болон бусад хэрэгслийг үнэ төлбөргүй олгох;

3/ хүнд нөхцөлд байгаа хүүхдийг үрчилсэн гэр бүлд төрөөс тэтгэмж олгох;

4/хүүхдийг асран хамгаалах байгууллагад шилжүүлж, халамжийн үйлчилгээнд хамруулах;

5/хүүхдийг сайн дурын үндсэн дээр асран хүмүүжүүлэх гэр бүлд дэмжлэг үзүүлэх.

Гэр орноосоо дайжсан хүүхдэд сургуулийн орчин нь нийгэмшиж, зөв мэдээлэл олж авах анхдагч нөхцөл болдог учир хохирогч хүүхдэд боловсролын үйлчилгээг заавал үзүүлдэг байх нь чухал. “Боловсролын тухай” хуулийн 32 дугаар зүйл зааснаар баг, хорооны Засаг даргын бүрэн эрхэд “суурь боловсрол эзэмшээгүй иргэнд нөхөн эзэмшүүлэх ажил зохион байгуулах” үйл ажиллагаа хамаардаг учир энэ зохицуулалттай уялдуулан, хамтран ажиллах зарчимд суурилан үйлчилгээг үзүүлэх нь үр дүнтэй байх юм.

Нийгмийн халамжийн тухай хууль /2005 оны 12 дугаар сарын 1-ний өдөр/

19 дүгээр зүйл. Нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмжийн төрөл

19.1. Нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмж дараах төрөлтэй байна:

19.1.6. Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийлийн улмаас сэтгэл санааны болон бие махбодийн хохирол хүлээж, хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж;

19¹ дүгээр зүйл. Нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмж авах эрх

19¹.1.2. Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийлийн улмаас сэтгэл санааны болон бие мах бодийн хохирол хүлээж хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг Гэр бүлийн тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа;

Үг хуульд заасан нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох журмыг Засгийн газар тогтоодог бөгөөд одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа журмыг 2008 оны 162 дугаар тогтоолоор /2 дугаар хавсралт/ баталсан байна.

“БЭЛГИЙН МӨЛЖЛӨГ, ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДИЙН ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ НЬ”

26 дугаар зүйл. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний төрөл, хамрах хүрээ

26.1. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай өрх, иргэнд үзүүлэх олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ дараах төрлтэй байна:

26.1.3. сэргээн засах үйлчилгээнд хамруулах;

26.1.4. түр байрлуулан асрамжлах;

26.2. Энэ хуулийн 26.1-д заасан үйлчилгээнд дор дурдсан иргэн, өрхийг хамруулна:

26.2.3. хүнд нөхцөлд байгаа хүүхэд;

26.2.4. хүчирхийлэлд өртсөн иргэн;

Энэ зүйл, заалтаар хүчирхийлэлд өртсөн иргэн, хүнд нөхцөлд байгаа хүүхэд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамж, үйлчилгээг авах эрхтэй юм.

Гэр бүлийн тухай хууль /1999 оны 6 дугаар сарын 11-ний өдөр/

25.5. Бүтэн өнчин, эцэг, эх нь хоёулаа эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон болон эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан, удаан хугацаагаар эмнэлэгт эмчлүүлж байгаа, хорих газарт ял эдэлж байгаа зэрэг хундэтгэн үзэх шалтгаанаар хүүхдээ биечлэн тэжээн тэтгэх, асран халамжлах бололцоогүй, эсхүл тэжээн тэтгэхээс зайлсхийсэн хүний хүүхдийн эрх, ашиг сонирхлыг сум, дүүргийн Засаг дарга хамгаална.

Энэхүү зохицуулалтаас харахад хүүхдийн эрх ашгийг хамгаалах субъект нь анхан шатны нэгжийн Засаг дарга байна. Энэ субъект нь суурь боловсрол олгох, мэргэжлийн сургалтад хамруулах, бичиг баримтжуулах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулах аргаар хүүхдийн эрх ашгийг хамгаалдаг.

Иргэний хууль /2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр/

497 дугаар зүйл. Гэм хор учруулснаас хариуцлага хүлээх үндэслэл

497.1. Бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл /эс үйлдэхүй/-ээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй.

Хохирогчийг хамгаалах, түүнд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх боломжийн нэг нь иргэний эрх зүйн хамгаалалт юм. Эрүүгийн хэрэг дэх иргэний нэхэмжлэлээс гадна хохирогч иргэний журмаар бие даасан нэхэмжлэл гаргах эрх нь нээлттэй байдагт уг боломжийн гол ач холбогдол оршдог. Тухайн гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрээр барагдуулах, өөрөөр хэлбэл сэтгэл санааны хувьд гэмт хэрэг үйлдэгдэхээс өмнөх байдалд оруулахад шаардлагатай сэтгэцийн эмгэг заслын үйлчилгээний төлбөр, хөдөлмөр эрхэлдэг байсан бол ажилгүй байсан хугацааны төлбөр, боловсрол эзэмшихэд шаардагдах зардал гэх мэт зүйлсийг энд дурьдаж болно. Эдгээр хохирлыг үнэлэн тогтооход зарим талаар хэцүү, маргаантай боловч хуульчдын

“БЭЛГИЙН МӨЛЖЛӨГ, ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДИЙН ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ НЬ”

хувьд ингэж хэвших нь бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн эрх ашгийг хамгаалахад томоохон дэвшил гарах “эхлэл” болох юм.

Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогч нь хувь хүний нууц болох нэр төр, бэлгийн амьдралтай холбоотой мэдээллийг агуулсан нэхэмжлэл гаргахад сэтгэл зүйн хүнд дарамт амсдаг. Ийм учраас энэ төрлийн гэмт хэрэгт эдийн болон эдийн бус гэм хорыг үнэлэх, нөхөн төлүүлэхээр төлөөлөн нэхэмжлэл гаргах, түүнийг хангасан шийдвэр гаргуулж хэвшүүлэх шаардлагатай.

Үг хуулийн Гуравдугаар дэд бүлгээр гэр бүлийн хөрөнгийн харилцааг зохицуулдаг бөгөөд хүүхэд гэр бүлийн гишүүнд тооцогддог. Энэ үүднээс хохирогч хүүхэд гэр бүлийн гишүүний хуваарьт хөрөнгийн хувьд шаардах эрх эдэлнэ. Иргэний эрх зүйд иргэний бүрэн чадамж 18 нааснаас эхэлнэ. Мөн чадамжгүй этгээдийн нэрийн өмнөөс түүний асран хамгаалагч нэхэмжлэл гаргах эрхтэй байдаг. Эдгээрийг тооцон үзэж хохирогчид ногдох хэсгийг нэхэмжлэх нь хохирогч хамгааллын бас нэг хувилбар байж болох юм. Хохирогч хүүхэд 18 нас хүрч бие даан амьдрах шаардлагатай болдог. Энэ үед үүссэн санхүүгийн зарим нэг асуудлыг шийдвэрлэх бас нэг хууль зүйн боломж юм.

PS: Иргэний эрх зүйн эдгээр боломжууд нь хохирогчийг хамгаалах арга хэрэглүүр болохоос эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл болохгүй гэдгийг дурдах нь зүйтэй.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /2004 оны 05 дугаар сарын 13/

6 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийллийн хэлбэр

6.1. Энэ хуульд заасан гэр бүлийн хүчирхийлэл нь бие махбодын, сэтгэл санааны, бэлгийн, эдийн засгийн хэлбэртэй байж болно.

Хуулийн энэхүү заалтад гэр бүлд үйлдэгддэг хүчирхийллийн хэлбэрийг тоочих замаар тодорхойлжээ. Хэрэв хохирогч хүүхэд гэр бүлийн хүчирхийллийн улмаас орон гэрээсээ дайжсан, эцэг, эхтэйгээ хамт амьдрах нь түүний амь нас, эрүүл мэндэд хохиролтой бол Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн дагуу түүнийг эсрэг хүчирхийлэл үйлдсэн гэр бүлийн гишүүдэд “эрх хязгаарлах арга хэмжээ” авахуулах боломжтой юм.